

Техник Импорт компаний хувьцааны нийлүүлэгчдийн 2012 оны 04 сарын 10 өдрийн 06 тоот тушаалын хавсралт 01



"Техник импорт" (ХК) хувьцаат

компаний дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. "Техник импорт" (ХК) компани нь нээлттэй Хувьцаат компани мөн.
- 1.2. Монгол улсын Иргэний хууль, Компаний тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компаний үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3. Компаний оноосон нэр: Монголоор "Техник импорт" (ХК) хувьцаат компани
Англиар "Technik Import" (JSC) Joint Stock Company
Регистрийн дугаар: 2057239
- 1.4. Компаний оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 5-р хорооны нутаг дэвсгэрт орших Техник импорт ХК-ний байранд.
- 1.5. "Техник импорт" ХК нь өөрийн нэр бүхий тэмдэгтэй, албан бичгийн хэвлэмэл хуудастай, бэлгэ тэмдэгтэй байна. Компаний бэлэгдэл, барааны тэмдгийн загварыг Төлөөлөн Удирдах Зөвлөл/цаашид "ТУЗ" гэх/ баталж Оюуны Өмчийн Газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн "Техник Импорт" ХК эдэлнэ.

Хоёр. Компаний эрх зүйн байдал

- 2.1. Монгол улсын хуулийн дагуу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар хувьцаат компаний хэлбэрээр байгуулагдаж улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээд мөн.
- 2.2. Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.
- 2.3. Компани нь хүлээсэн үүргээ өөрийн эд хөрөнгөөр хариуцах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 2.4. Компани нь санхүүгийн хүчин чадлаа дээшлүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа гаргах, банк болон бусад байгууллагаас зээл авах, өрийн бичиг гаргаж болно.
- 2.5. Компани нь өөрийн хөрөнгөө үр ашигтай байршуулах, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх зориулалтаар бусад хуулийн этгээдийн хувьцаа, өрийн бичиг худалдан авах, худалдах хувь нийлүүлэх, хуулийн этгээд үүсгэн байгуулж болно.

2.6.Компани нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүдийг байгуулж ажиллуулах, гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хамтарсан ажил үйлчилгээ эрхлэх, өөрийн салбар болон төлөөлөгчийн газар нээн ажиллуулах эрхтэй байна. Компаний салбар төлөөлөгчийн газрын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн ТУЗ-ийн шийдвэрээр баталж мөрдүүлнэ.

2.7.Компани нь Монгол улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

Гурав. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл

3.1.Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

3.2. Компанийн эрхэм зорилго: Техник Импорт ХК нь компанийн засаглал, ил тод байдлыг баримтлан ажиллаж, Монгол улсын хууль дүрмийг чандлан сахихаас гадна Олон улсын жишиг, стандартыг дагаж мөрддөг, зах зээл дэхь өрсөлдөгч болон хамтрагч , харилцагч нартай бизнесийн таатай орчинг бүрдүүлэн ажилладаг,нийгмийн хариуцлагыг идэвхитэй хэрэгжүүлэгч үндэсний шилдэг компани байна.

3.3.Компани нь үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ болон хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.

Дөрөв.Компанийн хувьцаа

4.1.Компанийн хувьцаа нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1446755 /нэг сая дөрвөн зуун дөчин зургаан мянга долоон зуун тавин таван/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

4.2.Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1446755 ширхэг энгийн хувьцаа байна.

4.3.Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно.Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг уг хувьцааг гаргах тухай шийдвэрт заана.

4.4.Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

Тав. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага

5.1.Компанийн энгийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч байна.

5.2.Энгийн Хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гарах үед ТУЗ-аас тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх.

5.2.2.Хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх.

5.2.3.Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах.

5.2.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон энэ дүрмийн 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах.

5.3.Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

5.3.1.Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх

5.3.2.Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнийг ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх

5.4.Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

Зургаа. Компанийн үнэт цаасыг гаргах худалдах, эргүүлэн авах

6.1.Компани тэргүүн энгийн хувьцааг заавал гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.

6.2.Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу гүйцэтгэнэ.

6.3.Хувьцаа нэмж гаргах, хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.

6.4.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.5.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджын 25 хувиас илүүгүй байна.

6.6.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болно.

Долоо. Компанийн удирдлага

Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

7.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

7.3.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ний дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухайн хуралд оролцогчдын олонхиос сонгогдсон дарга удирдана. Хэрэв хурал өөр хүн сонгоогүй бол хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдана.

7.5.Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар ээлжит бус хурлыг Компаний тухай хуулийн 61-р зүйлд заасан журмын дагуу гаргана.

7.6.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг ТУЗ гаргах ба уг шийдвэрт дараах асуудлыг заавал тусгана. Үүнд:

- хурал хуралдуулах газар, өдөр, цаг
- хурлаар хэлэлцэх асуудал
- хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
- хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам
- хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт
- саналын хуудасны агуулга

- саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр
- хурлын дарга
- тооллогын комиссын дарга, гишүүд

7.7.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг дээрхи шийдвэрийг гаргаснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

7.8.Энэ тухай шийдвэр гаргаснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг компани нийтэд мэдээлнэ.

7.9.Дор дурьдсан тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргана. Үүнд:

- ТУЗ-ийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон
- ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан
- Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн
- Компанийн өр нь өөрийн хөрөнгөөс 2 жил дараалан илүү болж, хасах утгатай болсон
- ТУЗ шийдвэр гаргасан
- Аудитын хорооноос ээлжит бус хурал хийхийг шаардсан

7.10.Хурал зарласнаас хойш хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.11.Дор дурьдсан асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.11.1.Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах.

7.11.2.Нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах.

7.11.3.Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох

7.11.4.Компанийн хэлбэрийг өөрчлөх

7.11.5.Компанийг татан буулгах болон татан буулгах комиссын байгуулах.

7.11.6.Хувьцааг хуваах буюу нэгтгэх

7.11.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох буюу бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох.



7.11.8.Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх

7.11.9.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

7.11.10.Компанийн тухай хуулийн 11-р бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах.

7.11.11.Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах.

7.11.12.Компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх

7.11.13.Хэрэв компанийн дүрмэнд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох

7.11.14.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

7.11.15.Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон бусад асуудлууд

7.12.Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй.

7.13.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор шийдвэрлэнэ.ТУЗ-ийн гишүүдийг "кумулятив" аргаар сонгоно.

7.14.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй.

7.15.Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг төлөөлөн удирдах зөвлөл хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр хурал хуралдах өдрөөс 45 хоногоос өмнө байна.

7.16.Хурал зарлагч этгээд нь хурлын тухай зар мэдээг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд, Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэх үүрэгтэй.

7.17.Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хуралаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

7.18.Нэмэлт саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний шалтгаан, санал оруулж байгаа хувьцаа эзэмшигчийн овог нэр, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоог тусгана.

7.19.Төлөөлөн удирдах зөвлөл нь гаргасан нэмэлт саналыг дор дурьдсанаас бусад тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоног дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ.

7.19.1.Санал гаргагч нь дүрмийн 7.13 дахь болзолыг хангаагүй.

7.19.2.Санал гаргагч дүрмийн 7.14 дахь мэдээллийг бүрэн тусгаагүй

7.20.Төлөөлөн удирдах зөвлөл нэмэлт саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

7.21.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

7.22.Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

7.23.Төлөөлж оролцох этгээд нь энэ тухайгаа Төлөөлөн удирдах зөвлөлд хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй. Хурал хойшилсон боловч хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

7.24.Хувьцаа эзэмшигч нь хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсонд тооцно.

7.25.Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох эсхүл шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

7.26.Компанийн саналын эрхтэй хувьцааны 65-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.27.Дүрмийн 7.26-д заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлоно. Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж үл болно.

7.28. Дүрмийн 7.26-д заасан хэмжээний хувьцаа эзэмшигчид оролцсон тохиолдолд хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

7.29.Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Уг хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс доошгүй хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр цагийг дахин мэдэгдэнэ.

7.30.Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

7.31.Түрүүчийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.

7.32.Хойшлогдсон хурал ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлана.

7.33.Хувьцаа эзэмшигчдийн саналыг санал авах хуудсаар авна.

7.34.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт өгөх саналаа санал авах хуудсанд тэмдэглэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоосон журмын дагуу тооллогын комисст ирүүлнэ.

7.35.Санал авах хуудсаар өгсөн саналыг дараахь тохиолдолд хүчинтэйд тооцно.

7.35.1.Ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн

7.35.2.Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг ердийн журмаар санал хурааж сонгох тохиолдолд нэр дэвшигчийг дэмжсэн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх

7.35.3.Кумулятив аргаар санал хураан сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

7.35.4.Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн байна.

7.36.Хувьцаат компани нь хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг санал авах хуудас ашиглан явуулна. Ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж үл болно.

7.37.Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Эчнээ санал явуулахдаа Компанийн тухай хуулийн 73-р зүйлийг баримтлана.

7.38.Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлийн дагуу гаргах бөгөөд хурлын дарга гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

7.39.Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, мөн оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч шүүхэд гомдол гаргаж болно.

Төлөөлөн удирдах зөвлөл

7.40.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байна.

7.41.Төлөөлөн Удирдах Зөвлөл 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг 1 жилийн бүрэн эрхийн хугацаагаар сонгоно.

7.42.ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан, ял шийтгэлгүй, компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохих бөгөөд ТУЗ-ийн дарга, гишүүд нь компанийн өдөр тутмын ажилд оролцохгүйгээр, гагцхүү ТУЗ-ийн шийдвэрийг гаргаж мөрдүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавих журмаар үйл ажиллагаагаа явуулна.

7.43.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн хувь нийлүүлэгч биш байж болно.

7.44.ТУЗ-ийн дарга орон тооны байж болно.ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүд дундаасаа сонгоно.

7.45.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хараат бус гишүүнийг ТУЗ-д сонгож чадаагүй тохиолдолд ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно.Дээр дурьдсан нөхцөл үүссэн тохиолдолд ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш ажлын 5 өдөрт багтаан дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тогтоож, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг дахин хэлэлцүүлнэ.

7.46.ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж, тэрчилгээ авсан байна.

7.47.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.47.1.Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох

7.47.2.Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө ба түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах

7.47.3.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

7.47.4.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

7.47.5.Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах

7.47.6.Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

7.47.7.Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

7.47.8.Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

7.47.9.Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох

7.47.10.Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох

7.47.11.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

7.47.12.Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

7.47.13.Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

7.47.14.Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

7.47.15.Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

7.47.16.Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.47.17.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох

7.47.18.Эрх бүхий албан тушаалтнаас компанид учруулсан хохирлыг төлүүлэх хэмжээг тогтоох

7.47.19.Гадаад, дотоодын байгууллага, банктэй хамтран ажиллах, хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр барьцаалан баталгаа гаргах

7.47.20.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

7.47.21.Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

7.48.Компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд



хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлаар гишүүнийг нөхөн сонгож болно. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 1 жил байна. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.

7.49. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийг зөвхөн бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож болно.

7.50. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувь хүн байна.

7.51. ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно. Энэ аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцаанд ноогдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсвэл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй.

7.52. ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүдийн хуралд биечлэн оролцож чадахгүй тохиолдолд хэлэлцэх асуудлын талаар саналаа бичгээр ирүүлж болно. Гэхдээ саналаа бичгээр ирүүлсэн гишүүнийг ТУЗ-ийн хурлын ирц хүчин төгөлдөр болоход тооцохгүй, гагцхүү тухайн хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад түүний ирүүлсэн саналыг саналын эрхтэй гэж үзнэ. Нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно

7.53. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар сонгоно.

7.54. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

7.55. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг томилсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн гүйцэтгэнэ.

7.56. ТУЗ-ийн дарга нь үйл ажиллагааны тогтоосон эрх хэмжээний дотор компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.

7.57. ТУЗ-ын хурлыг 2 сард 1 удаа хуралдуулна, шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд гарын үсэг зурна.

7.58. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, аудитын хороо, гүйцэтгэх захирлын шаардлагаар хуралдуулна. ТУЗ үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

7.59. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнхи олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

7.60. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.

7.61. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл байнгын болон түр хороог өөрийн дэргэдээ байгуулж болно.

7.62. ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёр нь хараат бус гишүүдээс бүрдэнэ. Дээрх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, компаний тухай хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас аудитын хороог хуралд оролцогсдын саналын дийлэнхи олонхоор сонгоно. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:
- компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах
- аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах
- Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцлийг боловсруулах;
- ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;



- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсноос ТУЗ-ийн гишүүн байсан хүнийг хуульд заасан хугацаанд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэрийг дэвшүүлэхээс татгалзах.

Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

- ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ.

- 1) Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компаний энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй
- 2) Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компаний болон компани оролцогч нь болж байгаа компаний нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй
- 3) Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй
- 4) Компанитай бизнесийн аливаа холбоогүй

Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй.

- ТУЗ ба Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих,
- зөрчил илэрвэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх
- компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.



7.63.ТУЗ нь даргын санал болгосноор ТУЗ-өөс томилсон нарийн бичгийн даргатай байх ба нарийн бичгийн дарга нь компаний тухай хуулийн 82.2-т заасан үүргийг хүлээнэ.

7.64.ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

7.65.ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцох бөгөөд тэдгээр нь компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

7.66.ТУЗ-ийн гишүүдэд компанийн цэвэр ашгийн 1 хүртэл хувийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн өгч болно.

Гүйцэтгэх захирал

7.67.Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

7.68.Компанийн Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн /цаашид "Гүйцэтгэх захирал" гэх/-ээр хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

7.69.ТУЗ компанийн Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр томилно.

7.70.Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байх, өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлсан итгэмжлэл авахгүй бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах:

2) Хараат (охин) компани, салбар, төлөөлөгчийн газрын Захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн гэрээ байгуулах:

3) Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах:

4) Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх:

5) Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах:

6) Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгуулага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах:

7) Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох:

8) Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх:

9) Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах:

10) Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах:

11) Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах:

12) ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар тайлагнах.

7.71. Гүйцэтгэх захирал нь ажлаа ТУЗ-д тайлагнах ба ТУЗ нь Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг хэдийд ч гаргах эрхтэй.

7.72. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг цуцалсан буюу цуцлах тухай санал тавьсан тохиолдолд Гүйцэтгэх захирлыг шинээр сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

7.73. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга, болон гишүүнд гаргаж болно.

**Найм. Компанийн эрх бүхий албан тушаалтан,
тэдгээрийн хариуцлага**



8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэнгүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

8.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

8.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

8.2.3. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

8.2.4. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

8.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

8.2.6. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

8.3. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 8.2.2-т заасан үүргийг хүлээнэ.

8.4. Албан тушаалтан энэ дүрмийн 8.2 болон 8.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

8.4.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

8.4.2. Хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

8.4.3. Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

8.4.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

8.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

8.5. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ

Ес. Компанийн ашгийг хуваарилах

9.1. Компанийн цэвэр ашгийг балансын нийт ашгаас бүх төрлийн татварын дүнг хасч тодорхойлно.

9.2.Компанийн цэвэр ашгаас компанийн хөгжлийн сан, аз туршилтын сан, нийгмийн арга хэмжээ, урамшууллын сан гэсэн сангууд байгуулж, үлдэх хэсэг нь ногдол ашиг болно.

9.3.Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргах ба ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

9.4.ТУЗ нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

9.5.Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

9.6.Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

1) Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2) Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

3) Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;

9.7.Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилахын өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

9.8.Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

9.9.Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно.

9.10.Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.

9.11.Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

9.12.Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

9.13.Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

9.14.Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

9.15.Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

Арав. Компанийн бүртгэл, баланс, тайлан

10.1.Компани нь үнэт цаас эзэмшигчдийнхээ бүртгэл болон компанийн бичиг баримтыг хадгалах журмыг Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл, 97 дугаар зүйлд нийцүүлэн ТУЗ тогтооно.

10.2. Эдгээр бүртгэл хадгалалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга биечлэн хариуцаж бичиг баримтыг хөтлөх үүрэг хүлээнэ.

10.3. Компани нь нягтлан бодох бүртгэл, компанийн санхүүгийн тайланг гаргахдаа компанийн тухай Монгол улсын хуульд заасны дагуу жил, улирлын баланс, тайлан гаргана.

10.4. Компани нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

10.5.Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа жил бүрийн 1-р сарын 1, дуусах хугацаа 12-р сарын 31 байна.

10.6.Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

10.7.Компани "Нягтлан бодох бүртгэлийн хууль"-д заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайлан гаргаж нийтлүүлнэ.

10.8.Санхүүгийн тайланд дараахь үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:

- 1) Баланс:
- 2) Орлого үр дүнгийн тайлан:
- 3) Мөнгөн гүйлгээний тайлан:
- 4) Хуримтлагдсан ашгийн тайлан:
- 5) Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн
- 6) Удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал

10.9.Санхүүгийн тайлан гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

10.10.Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайдын баталсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт, аргачлалыг мөрдөнө.

10.11.Компанийн ТУЗ удирдлагын үйл ажиллагааны тайлангаа гаргаж жил бүр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

Арван нэг. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

11.1.Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитийн хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

11.2.Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.

11.3.Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

11.4.Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.



11.5.Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.

11.6.Компанийн ТУЗ аудиторыг сонгож түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

11.7.Аудиторын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж гэрээг нь байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө.Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

11.8.Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

11.9.Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

11.10.Дараахь этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:

1) Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл зорилготой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилчин:

2) Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас эсвэл Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшигч:

3) Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд.

11.11.Аудиторт олгох хөлсний хэмжээг түүний гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан тогтоохыг хориглоно.

11.12.Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргана.

11.13.Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалтхийнэ.

11.14.Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах

12.1.Компани бусад компаниудыг нэгтгэж томрох, өөрөөсөө шинэ компани байгуулах аргаар өөрчлөн байгуулалт хийж болно.

12.2.Компани гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хамтарсан хөрөнгө оруулалттай компани байгуулж болно.

Арван гурав. Компани татан буугдах, хөрөнгө хуваарилах

13.1.Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

13.2.Шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

13.2.1.Дампуурсан;

13.2.2.Нэг ч гишүүн үлдээгүй;

13.2.3.Хуульд заасан бусад үндэслэл.

13.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар татан буугдаж байгаа ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

13.4.Татан буулгах комиссыг томилсноор компанийн ТУЗ болон Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн өрлцөнө.

13.5.Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

13.6.Компанийг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассан өдрөөс татан буугдсанд тооцно.

13.7. Татан буулгах комисс томилсноор компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно.Татан буулгах комисс дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1.Компанийг татан буулгах шийдвэрийг нийтэд мэдээлэх,

2.Дуусгалтын баланс, тайлан гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх,

3.Өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу батлах,



4.Үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилах,

5.Татан буулгах ажиллагаа дууссаныг Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж, бүртгэлээс хасуулах.

13.8.Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ.Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацааг нийтэд мэдээлснээс хойш 3 сар байна.

13.9.Татан буулгах шийдвэр гарах үед компани ямар нэг өргүй байвал компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлэхгүй байж болно.

13.10.Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.

13.11.Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.

13.12.Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол татан буулгах комисс компанийн эд хөрөнгийг худалдаж болно. Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө эсвэл тэдгээрийг худалдаж борлуулсны орлогыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.

13.13.Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.

13.14.Компанийг бие даасан өөр компанитай нэгтгэж шинээр компани байгуулах, эсвэл өөр компанийг өөртөө нийлүүлэх буюу өөрөө өөр компанид нийлэх, түүнчлэн компанийг бие даасан хэд хэдэн компани болгон хуваах буюу компаниас өөр компани шинээр тусгаарлах аргаар өөрчлөн байгуулж болно.

13.15.Компани нь өөртөө өөр компани нийлүүлсэн, өөрөөсөө шинээр компани тусгаарлан гаргасан тохиолдолд тус компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхээ хадгалж үлдэнэ.

Арван дөрөв. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт

14.1.Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна.

14.2.Энэхүү дүрэм нь Улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.